

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.340.20, 13.100

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл. Толгой хамгаалах хэрэгсэл- Хамгаалалтын дуулга	MNS 5621:20XX
Occupational safety and health. Personal protective equipment. Head protection- Protective helmet	MNS 5621:2006-ын оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын ... оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь ... оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь гадны болон механик биет толгой дээр унах эрсдэл бүхий ажил үйлчилгээ эрхэлдэг бүх аж ахуйн нэгж, байгууллагад хамаарна.

2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

ISO 3873- Аж үйлдвэрийн хамгаалалтын малгай

EN 397 /Европын норм/

MNS 4931, Хамгаалах хэрэгсэл. Ерөнхий шаардлага. ангилал

3 Нэр томъёо, тодорхойлолт

3.1

хувийн хамгаалах хэрэгсэл

Хөдөлмөрлөх явцад ажлын байрны аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хүнийг хамгаалах зориулалт бүхий хэрэгсэл.

3.2

дуулга

Гадны болон механик биет, халуун, хүйтний нөлөөнөөс толгойг хамгаалах хэрэгсэл.

3.3

дуулганы дагалдах хэрэгсэл

Тусгай зориулалтын нэмэлт эд анги, тухайлбал эрүүний оосор, хүзүүний хамгаалалт, оосор, чийдэн ба кабелийн бэхэлгээний төхөөрөмж

4 Зориулалт

Толгой хамгаалах дуулгыг дараах байдлаар ангилна. Үүнд :

- 4.1 Толгой хамгаалах дуулга
- 4.2 Нэмэлт хамгаалах хэрэгсэлтэй дуулга
- 4.3 Сонсгол хамгаалах хэрэгсэлтэй дуулга
- 4.4 Нүд хамгаалах хэрэгсэлтэй дуулга
- 4.5 Нүүр, нүд хамгаалах хэрэгсэлтэй дуулга
- 4.6 Нүүр, нүд, сонсгол хамгаалах хэрэгсэл (иж бүрдэл)-тэй дуулга

5 Ерөнхий зүйл

5.1 Зорилго

Энэ стандартын зорилго нь ажилтны толгойг гадны болон механик биет, халуун, хүйтний нөлөөллөөс хамгаалах дуулганд тавих шаардлагыг тогтооход чиглэнэ.

5.2 Ерөнхий шаардлага

- 5.2.1 Хамгаалалтын дуулга нь MNS 4931, Хамгаалах хэрэгсэл. Ерөнхий шаардлага. ангилал болон Олон Улсын стандартын шаардлагыг хангасан байна.
- 5.2.2 Хамгаалалтын дуулга нь зориулалтын дагуу ашиглахад тохирсон байна.
- 5.2.3 Хамгаалалтын дуулга нь эрх бүхий байгууллагаар шалгагдаж баталгаажуулсан гэрчилгээтэй байна.

5.3 Тусгай шаардлага

- 5.3.1 Хамгаалалтын дуулга нь толгой дээр гадны биет унахад толгойг хамгаалахаас гадна, хөлсийг зайлуулах агааржуулагчтай байна.
- 5.3.2 Сонсгол хамгаалах хэрэгсэлтэй дуулга нь 85 дБ-ээс дээш шуугианыг үйлдвэрийн бүх давтамжид найдвартай бууруулж, чихэвч нь хүний чихэнд сөрөг нөлөөгүй байна.
- 5.3.3 Нүд хамгаалах хэрэгсэлтэй дуулга нь хөдөлмөрийн нөхцөлөөс шалтгаалан тунгалаг (салхины хүч нь 12-190 м/с), гэрлийн бууралт (0-11 DIN бууруулах)-тай ба өнгө үзэмжтэй, харшил өгөхгүй, нүдийг гадны биетээс найдвартай хамгаалсан байна.
- 5.3.4 Нүүр, нүд хамгаалахаас гадна нүүрийг өөрийн техникийн үзүүлэлтийн хүрээнд хүний эрүүл мэндэд сөрөг хор нөлөөгүйгээр хамгаалсан байна.
- 5.3.5 Нүүр, нүд, сонсгол хамгаалах хэрэгсэлтэй (иж бүрдэл) дуулга нь энэхүү стандартын 5.3.1, 5.3.2, 5.3.3, 5.3.4-д заасны дагуу хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр хамгаалсан байна.

6 Дуулганы техникийн үзүүлэлт

6.1 Толгой хамгаалах дуулганы техникийн үзүүлэлт

- 6.1.1 Механик үйлчлэлийн үед толгойг найдвартай хамгаалах чадвартай байна.
- 6.1.2 Дуулганы ММ-механик үйлчлэл 400-1000 VAC цахилгаан хүчдэл - 50⁰С-ээс +150⁰ температур, LD-гэрлийн нөлөөллөөс толгойг найдвартай хамгаалах чадвартай polyethelene-PE, polycarbonat-PC материалаар хийсэн байна.

6.2 Сонсгол хамгаалах хэрэгсэлтэй дуулганы техникийн үзүүлэлт

Сонсгол хамгаалах хэрэгсэлтэй дуулга нь энэхүү стандартын 6.1-ийн 6.1.1, 6.1.2-д болон 5.3.2-д заасан шаардлагуудыг тус тус хангасан байна.

6.3 Нүд хамгаалах хэрэгсэлтэй дуулганы техникийн үзүүлэлт

Нүд хамгаалах хэрэгсэлтэй дуулга нь энэхүү стандартын 6.1-ийн 6.1.1, 6.1.2-д болон 5.3.3-д заасан шаардлагуудыг тус тус хангасан байна.

6.4 Нүүр, нүд хамгаалах хэрэгсэлтэй дуулганы техникийн үзүүлэлт

Нүүр, нүд хамгаалах хэрэгсэлтэй дуулга нь энэхүү стандартын 6.1-ийн 6.1.1, 6.1.2-д болон 5.3.4-д заасан шаардлагуудыг тус тус хангасан байна.

6.5 Нүүр, нүд, сонсгол хамгаалах хэрэгсэлтэй дуулганы техникийн үзүүлэлт

Нүүр, нүд, сонсгол хамгаалах хэрэгсэлтэй дуулга нь энэхүү стандартын 6.1-ийн 6.1.1, 6.1.2-д болон 5.3.5-д заасан шаардлагуудыг тус тус хангасан байна.

7 Дуулганы бүтэц**7.1 Толгой хамгаалах дуулганы бүтэц.**

- 7.1.1 Толгой хамгаалах Дуулганы их бие
- 7.1.2 Толгойд өмсөх бүслэвч
- 7.1.3 Толгойд тохируулах цагариг
- 7.1.4 Толгойн оройноос хөндийрүүлэх татуурга
- 7.1.5 Толгойн хөлс шингээгч жийргэвч

7.2 Сонсгол хамгаалах хэрэгсэлтэй дуулганы бүтэц

- 7.2.1 Толгой хамгаалах хэрэгсэл нь энэхүү стандартын 7.1-д заасан бүтэцтэй адил байна.
- 7.2.2 Чихэвч суулгах хоног
- 7.2.3 Стандартын чихэвч
- 7.2.4 Чихэвчийг тохируулах холбоос

7.3 Нүд хамгаалах хэрэгсэлтэй дуулганы бүтэц

- 7.3.1 Толгой хамгаалах дуулга нь энэхүү стандартын 7.1-д заасан бүтэцтэй адил байна.
- 7.3.2 Нүдний шил тогтоогч суурь
- 7.3.3 Ногоон, шар нүдний шил

7.4 Нүүр, нүд хамгаалах хэрэгсэлтэй дуулганы бүтэц

- 7.4.1 Толгой хамгаалах хэрэгсэл нь энэхүү стандартын 7.1-д заасан бүтэцтэй адил байна.
- 7.4.2 Нүүрэвч тогтоох бүс
- 7.4.3 Нүүрэвчийн хөдөлгөөнийг тохируулах тэнхлэг
- 7.4.4 Нүүрэвчийг тэнхлэгт бэхлэх түгжээ
- 7.4.5 Цагаан, өнгөт, металлын нүүрэвчүүд

7.4.6 Нүд хамгаалах хэрэгсэл

7.5 Нүүр, нүд, сонсгол хамгаалах (иж бүрдэл) дуулганы бүтэц

Нүүр, нүд, сонсгол хамгаалах (иж бүрдэл) дуулга нь энэхүү стандартын 7.1, 7.2, 7.3, 7.4-д заасан бүтэцтэй адил байна.

8. Хэрэглэх ба шалгах арга

8.1 Толгой хамгаалах дуулгыг хэрэглэх ба шалгах арга

- 8.1.1 Толгой хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдал, зөв угсарсан эсэх, техникийн үзүүлэлт, хөдөлмөрийн нөхцөлд тохирч буй эсэхийг нарийн шалгаж, тогтооно.
- 8.1.2 Толгой хамгаалах хэрэгслийн өмсөх бүслэвчийг өөрийн толгойны хэмжээнд тохируулан өмсөж, тохируулагч цагаригаар хэмжээг тохируулж хөдөлгөөнгүй суулгаж, толгойгоо хамгаалсны дараа ажлаа эхэлнэ.

8.2 Сонсгол хамгаалах хэрэгсэлтэй дуулгыг хэрэглэх ба шалгах арга

- 8.2.1 Толгой хамгаалах хэрэгслийн чихэвч суулгах хоногт чихэвч (25-40 дБ бууруулах)-ийг угсарч, чихэвч суулгах холбоосны тэнхлэгийн дагуу хэмжээг нь тохируулна.
- 8.2.2 Чихэвч нь шуугиан бууруулахаас гадна бэхэлгээний үүргийг давхар гүйцэтгэнэ.
- 8.2.3 Сонсгол хамгаалах хэрэгсэлтэй дуулгыг энэхүү стандартын 8.1-ийн шаардлагын дагуу өмсөж, толгой ба сонсголоо иж бүрэн хамгаалсны дараа ажлаа эхэлнэ.

8.3 Нүд хамгаалах хэрэгсэлтэй дуулгыг хэрэглэх ба шалгах арга

Нүд хамгаалах тусгай зориулалтын шилний суурийг толгой хамгаалах хэрэгсэлд угсарч, дараа нь нүд хамгаалах шилээ зүүж, энэхүү стандартын 8.1-ийн шаардлагын дагуу дуулгаа өмсөж, толгой, нүд хараагаа бүрэн хамгаалж ажлаа эхэлнэ.

8.4 Нүүр хамгаалах хэрэгсэлтэй дуулгыг хэрэглэх ба шалгах арга

- 8.4.1 Ажлын байрны нөхцөлөөс шалтгаалан янз бүрийн өнгөтэй болон металлын нүүрэвчийг сонгож дараа нь толгой хамгаалах хэрэгсэлд тогтоогч бүсийн тусламжтай суулгаж, тохируулах тэнхлэгт нь түгжиж энэхүү стандартын 8.1-д заасны дагуу өмсөж, толгой, нүүрээ хамгаалсны дараа ажлаа эхэлнэ. Үс орооцолдохоос сэргийлж, үсийг заавал бооно. Хүйтнээс хамгаалах, их хэмжээний /100мг/м³-ээс дээш/ тоостой үед дуулганы дотор талд нэмэлт малгайг давхар өмсөнө.
- 8.4.2 Нүүрэвч нь тэнхлэг дээрээ дээш, доош эргэх бөгөөд шаардлагатай цэгт түгжиж болно.

8.5 Нүүр, нүд, сонсгол хамгаалах (иж бүрдэл) дуулгыг хэрэглэх ба шалгах арга

Иж бүрдэл хэрэгслийг энэхүү стандартын 8.1, 8.2, 8.3, 8.4-д заасны дагуу өмсөж,

толгой, нүүр, нүд, сонсголоо хамгаалж ажлаа эхэлнэ.

9. Хадгалах нөхцөл, хугацаа

Толгой хамгаалах хэрэгслийг 60 хувиас бага чийгшилттэй, -50С +200С-д битүү сав (баглаа, боодол)-д хадгална. Ашиглалтын хугацаа элэгдлээс хамаарна.

10. Анхаарах зүйл

- 10.1** Толгой хамгаалах хэрэгслийн техникийн үзүүлэлт, тухайн ажилтны хөдөлмөрийн нөхцөлд бүрэн тохирч байгаа эсэх.
- 10.2** Толгой хамгаалах хэрэгслийн техникийн бичиг баримт, хяналтын албаны зөвшөөрөл, хамгаалах хэрэгсэл хоорондоо тохирч байгаа эсэх.
- 10.3** Ашиглах, хэрэглэх арга нь энэхүү стандартын дагуу явагдаж байгаа эсэхийг байнга шалгаж байна.

ТӨГСӨВ.

А хавсралт
(мэдээллийн)

Хүснэгт А.1

Хамгаалалтын дуулга, хамгаалах хэрэгслийн техникийн үзүүлэлт

№	Хамгаалах хэрэгслийн ангилал	Техникийн үзүүлэлт
1	Толгой хамгаалах дуулга	-30 ⁰ С +150 ⁰ С, 440-1000 VAC, MN, жин 300 гр хүртэл
2	Сонсгол хамгаалах хэрэгсэл	27дб-35дб, жин 100 гр хүртэл
3	Нүд хамгаалах хэрэгсэл	35 гр, 3-7 DIN
4	Нүүр, нүд хамгаалах хэрэгсэлтэй дуулга	45-195 м/с, 3-7 DIN
5	Нүүр, нүд, сонсгол хамгаалах хэрэгсэлтэй (иж бүрдэл) дуулга	-30 ⁰ С +150 ⁰ С, 440-1000 VAC, MN, 435 гр, 27-35дб, 3-7 DIN, 45-195 л/н